



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/32

Дэлгэрмөрөн

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Хамтдаа шийдье” гэр бүлд чиглэсэн сургалт мэдээлэл, сурталчилгааны ажлыг 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрөөс 05 дугаар сарын 21-ны өдөр хүртэл 3 хоногийн хугацаанд багуудад ажиллах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрт үйл ажиллагааг хэрэгжүүлэгч аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын өгсөн заавар, чиглэлийн дагуу бэлтгэл ажлыг хангаж, ажлын гүйцэтгэлийг илтгэх хуудсаар тайлагнаж, мэдээлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Багийн Засаг дарга нар явах замын маршрут, орох өрхийн тооцооллыг гаргаж, автомашины техникийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг анхааруулсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА



С.СУМЪЯАБАЗАР

D /bichig hereg/ Zahiramj -2022 on

• 642201063

Сумын Засаг даргын 2022 оны
5 дугаар сарын 18-ны өдрийн
А/СХ тоот захирамжийн хавсралт



БАГУУДАД АЖИЛЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Хөх бүрд 1 дүгээр баг
Б.Содномдаржаа (Газрын даамал)
Ц.Ганбаатар (жолооч)
Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн
Б.Нарантуяа (СӨБ-ын арга зүйч)
2. Сонор 2 дугаар баг
Г.Баасандорж (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Р.Мөнхбилэг (Тамгын газрын нягтлан бодогч)
Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн
Б.Жавзандулам (СӨБ-ын багш)
3. Норовлин 3 дугаар баг
П.Түвшинтөгс (Багийн Засаг дарга)
Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн
Ц.Нямсүрэн (СӨБ-ын багш)
4. Цорж 4 дүгээр баг
Б.Батшагай (Багийн Засаг дарга)
Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн
Ц.Мөнхцэцэг (СӨБ-ын багш)
С.Очирбат (Багийн Засаг дарга)
5. Дэлгэрмөрөн 5 дугаар баг
Г.Баасандорж (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
С.Очирбат (Багийн Засаг дарга)
Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн